# 2019-2023 онд тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрээ өөрчлөн тогтоолгох хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх талаар НДЕГ-аас гаргасан зөвлөмж

Нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх, тэтгэврээ өөрчлүүлэх хүсэлтийг тэтгэвэр авагч, иргэдийг нийгмийн даатгалын хэлтэст биеэр ирүүлэхгүйгээр хүлээн авах, тэтгэврийн өөрчлөлтийн мэдээллийг ил тод байлгах зорилгоор www.ndaatgal.mn сайтын даатгуулагчийн вэб хэсэгт тэтгэвэр авагчийн тэтгэврээ өөрчлүүлэх хүсэлтийг цахимаар хүлээн авах, баталгаажуулах боломжийг бүрдүүллээ.

Түүнчлэн төрийн үйлчилгээний цахим систем e-mongolia-д иргэн тэтгэврээ өөрчлүүлэх хүсэлтээ цахимаар гаргах нөхцөлийг бүрдүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулж байна.

Нийгмийн даатгалын байгууллагад 2019-2023 онд хүсэлт гаргаж, тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг өөрчлөн тогтооно.

- Тэтгэвэрээ өөрчлөн тогтоолгох хүсэлтийг цаасан эсхүл цахим хэлбэрээр 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 2023 оны 12 дугаар сард багтаан хүлээн авна.

- 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлт ирүүлсэн тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоож, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгоно.

**ЗӨВЛӨМЖ**

- 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлт ирүүлсэн тэтгэвэр авагчийн тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгон тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлийн 23.6 дах хэсэгт заасан хугацааг баримтлан шийдвэрлэнэ.

- Тэтгэвэр авагчийн тэтгэвэр бодох дараалсан 5 жилийн цалин хөлсийг анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан 6 эсхүл 7 жилийн жилийн цалин хөлснөөс, түүнчлэн тэтгэвэр тогтоолгосны өмнөх шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль өөрт ашигтай 5 жилийн цалин хөлснөөс сонгон өөрчлөн бодно.

Тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолгосны өмнөх шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийн сар бүрийн цалин хөлсийг Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолоор баталсан итгэлцүүрээр өсгөн, мөн тогтоолын 3-т заасны дагуу сарын цалин хөлсний дээд хэмжээг баримтлан тооцсон нийт цалин хөлсний нийлбэрийг 60-д хуваах замаар тэтгэвэр бодох сарын цалин хөлсний хэмжээг тодорхойлж тухайн тэтгэврийг анх тогтоосон бодолтын дагуу өөрчлөн тогтооно.

## ЗӨВЛӨМЖ

- Тэтгэвэр авагчийн өөрчлөн тогтоогдсон тэтгэврийг Засгийн газрын 2023 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 дүгээр тогтоолын дагуу 10 хувиар нэмэгдүүлж олгоно.

- Иргэний өөрчлөн бодсон тэтгэврийн хэмжээ тухайн тэтгэвэр авагчийн 2023 оны 12 дугаар сард авч байсан тэтгэврийн хэмжээнээс буурахаар бол тэтгэврийг өөрчлөн тогтоохгүй хэвээр олгоно.

- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дах хэсэгт тэтгэврээ 6 эсхүл 7 жилийн цалингийн дунджаас тогтоолгосон тэтгэврийг 5 жилийн цалин хөлснөөс зөвхөн 1 удаа өөрчлөн тогтоолгохоор заасан тул тэтгэвэр авагч 1 удаа хүсэлтээ гарган тэтгэврээ өөрчлөн бодуулж, тэтгэвэр нь баталгаажсан тохиолдолд уг тэтгэвэр бодсон энэ цалин хөлсийг дахин өөрчлөхгүй.

- Өөрчлөн тогтоосон тэтгэврийн тогтоолтын хуудсыг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус тус хэвлэн тэтгэврийн болон хяналтын байцаагч, тасгийн, хэлтсийн даргын гарын үсэг, тэмдгээр баталгаажуулан, тэтгэврийн хувийн хэрэгт хавсаргана.

- Тэтгэвэр авагчид хэлтэст биеэр ирж үйлчлүүлэх тохиолдолд хүсэлтийг цаасаар авч, зөвлөмжийн дагуу тэтгэврийг өөрчлөн тогтоох ажлын ачааллыг урьдчилан тооцож, үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай үзүүлж ажиллана.




Тэтгэврээ өөрчлүүлэх хүсэлтийг тэтгэвэр авагч, иргэд www.ndaatgal.mn вэб хуудасны даатгуулагчдад зориулсан вэб рүү хандаж, цахимаар гаргана.

Бүртгүүлсэн мэйл хаягаа оруулна




Үргэлжлүүлэх товчийг дарж нууц үгээ оруулна

Тэтгэвэр цэсийг сонгоно

Дэд цэсийг сонгоно






Тэмдэглэсэн цэсийг сонгоно

Тэмдэглэсэн 2 сонголтын аль өөрт ашигтайг сонгоно.



Хүсэлт илгээх товчийг дарна.






Хүсэлтээ илгээнэ.




Танд ирэх хариу ийм байна.

Эсвэл та гараар бичсэн өргөдлөө цахим болгож, тус хэлтсийн доорх мэйл хаягаар илгээж болно.

Sbdndaatgal@gmail.com

Эсвэл та Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст өөрийн биеэр ирж тэтгэврээ өөрчлүүлэх хүсэлтээ гаргаж болно.




Бид танд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх болно. Танд амжилт хүсье.

# СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

https://suhbaatar-duureg.ndaatgal.mn

7000-4300

Сүхбаатар Дүүрэг Нийгмийн Даатгалын Хэлтэс

sbdndaatgal@gmail.com